



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/ЗЧ

Мөрөн сум

“Аймгийн алдарт уяач” цол олгох
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.7, 13 дугаар зүйлийн 13.1.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арван долдугаар жарны Шороон гахай жилийн сар шинийн баярыг тохиолдуулан Монгол түмний баяр наадамд молор эрдэнэ болсон эрдэнэт хүлгээ аймаг, бүсийн наадамд олон жил уяж сойн уралдуулж, олон айраг түрүү хүртэж, морин спортыг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсныг өндрөөр үнэлж хавсралтад дурдсан нэр бүхий уяачдад “Аймгийн алдарт уяач” цол олгосугай.

2. Аймгийн алдарт уяачдад олгох 1,100,000 төгрөгийг аймгийн Засаг дарга данснаас гаргаж зарцуулахыг аймгийн Төсвийн ерөнхий нягтлан бодогч (Ц.Мөнхтуяа)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Л.ГАНБОЛД